

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
02/28 албан тоотын хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН
ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн Газраас харилцаа холбоо, мэдээллийн технологийг нийгэм, эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр тодорхойлсноор “Цахим Үндэстэн” болох хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхээр дэвшүүлж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн шинэчлэлт өөрчлөлтийг хийснээр 2022 оноос Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулан ажиллаж эхэлсэн, салбарын хууль эрхзүйн ялангуяа цахим орчин, мэдээллийн аюулгүй байдал, зөвшөөрлийн хуулийн орчин шинэчлэгдсэн онцлог жил байлаа.

УИХ-аас Харилцаа холбооны тухай хууль болон салбарын бусад¹ хуулиудад 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлт орсон, 2022 онд Цахим хөгжлийн багц хуулиуд (Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль), Зөвшөөрлийн тухай хууль шинээр болон шинэчлэгдэн батлагдсантай холбоотой Харилцаа холбооны зохицуулах хороо нь дараах бүрэн эрх, чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Харилцаа холбооны салбарт мөрдөгдөх норматив баримт бичгийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих²;
2. Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
3. Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
4. Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхпэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;
5. Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
6. Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах³;
7. Шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах⁴;
8. Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;
9. Радио долгионы асуудлаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх⁵;

¹ Радио долгионы тухай хууль. Шуудангийн тухай хууль

² Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3

³ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.16

⁴ Шуудангийн тухай хуулийн 9.1.5

⁵ Радио долгионы тухай хуулийн 5.1

10. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх⁶; Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдээллийн хэрэгсэл болсон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хяналт тавих, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах чиг үүрэг хүлээлгэсэн болно. Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд Монгол улсад ардчиллын үнэт зүйл болсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, олон талт мэдээ, мэдээлэл авах иргэний эрхийг хүндэтгэх хуулийн зорилт, зарчмын хүрээнд өргөн нэвтрүүлгийг хараат бус байлгах, даяаршлын эрин үед Монгол улсын үндэсний болон нийтийн нийтлэх эрх ашгийг радио, телевизийн салбарт хамгаалах зорилт тулгарч байна.

Харилцаа холбооны зах зээлийн нөхцөл байдал, харилцагчийн сэтгэл ханамж, хууль эрхзүйн ба бодлогын шинэ орчин, технологийн хурдацтай өөрчлөлт үйл ажиллагааг тодорхойлох, мэдэрч ажиллах зохицуулагч нарын зорилт байсаар ирсэн бөгөөд үйл ажиллагаагаа илүү мэргэжлийн, технологийн болон бодлогын хөгжилд нийцсэн, үр ашигтай байлгаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд эдгээр орчны өөрчлөлт, нөлөөллийг зөв, хурдтай мэдэрч, судалгаанд суурилсан, оновчтой зохицуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэх нь нэн чухал зорилт болж байгаа юм.

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх) нь Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, ирэх 2 жилийн төсвийн төсөөлөл”-ийн төслийг тус тус хуралдаанаар хэлэлцэж, Хорооны хуралдааны тогтоол, хавсралтаар баталдаг. ХХЗХ-ны жил бүрийн “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилт болон үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг тус тус гарган ЗГХЭГ-т хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдад хэрэгжилтийг шууд тайлагнаж ажиллаж байна.

Түүнчлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 02 сарын 17-ны өдрийн 43 тоот “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж, байгууллагын орлого зардлын төлөвлөгөөнд хяналт тавин хэрэгжүүлдэг болно.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос 2022 оны тайлант хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 80 тоот тогтоолын хавсралтаар баталсан **“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого зардлын төлөвлөгөө, байгууллагын 2023-2024 оны төсвийн төсөөлөл”**-д заасан зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ (зохицуулалтын баримт бичиг, техникийн болон зохицуулалтын нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, ашиглалт, төлбөрийн хэмжээ, төсөл хөтөлбөр)-ний талаар Даргын зөвлөл, Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж ажилласан.

⁶ Цахим гарын үсгийн тухай хуулийн 32.1

УИХ-аас баталсан хууль, тогтоомж болон Засгийн газрын 2016 оны 256 дугаар тогтоолоор баталсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм, 2020 оны 65 тоот тогтоолоор дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, хорооны хуралдааны дэгийн хүрээнд удирдлагаас өгсөн удирдамж чиглэл, “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги”, Хорооны 2021 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний зорилт, заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

ХХЗХ-ны хуралдаанаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 3 бүлэгт стратегийн зорилтын хүрээнд 273 бүтээгдэхүүн, зорилт заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан. Хорооны ажлын алба, бүтцийн нэгж 11 субъектээс 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан 3 үндсэн зорилтын дагуу Стратеги зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ (98), Нийтлэг (өдөр тутмын) ажил үйлчилгээ (67), Эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах, хамтран ажиллах (13) бүтээгдэхүүн, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллав.

ХХЗХ-ны Даргын 2021 оны А/56 тоот тушаалаар баталсан “Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл үнэлэх аргачлал”-ын хүрээнд Даргын 2022 оны А/115 тоот тушаалаар “ХХЗХ-ны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд мониторинг, үнэлгээ хийх ажлын хэсэг” байгуулан ажиллаж, аргачлалд заасан үзүүлэлтийн хүрээнд Дотоод хяналт, аудитын алба болон ажлын хэсгээс 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал бүр үнэлгээ дүгнэлтийг гаргаж, Даргын зөвлөлийн хуралдаанаар тухай бүр хэлэлцүүлэн гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэн тайлagnan ажиллав.

ХХЗХ-ноос 2022 онд салбарын болон шинээр боловсруулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан холбогдох хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх, хамтран ажиллах ажлын хүрээнд УИХ, ЗГХЭГ, ЦХХХЯ зэрэг яам байгууллага, хууль санаачлагч нартай “Нийтийн мэдээллийн тухай хууль”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, “Кибер аюулгүй байдлын тухай хууль”, “Зөвшөөрлийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, “Цахим гарын үсгийн тухай хууль” болон “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Зөвшөөрлийн тухай хууль”-ийн төслүүд дээр дэмжлэг үзүүлж дэд ажлын хэсэг, хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж, салбарын яам байгуулах, хөгжлийн төлөвлөлт, мэдээллийн ба кибер аюулгүй байдлын шинэ зохицуулалтыг бүрдүүлэх, боловсронгуй болгох талаар ажлын хэсгийн хүрээнд хамтран ажилласан. Түүнчлэн ХХЗХ-ноос Газрын багц хуулийн төсөлд тусгах саналыг БХБЯ, ЦХХХЯ; Орон сууцны ашиглалтын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж саналаа тусгуулсан; Саадгүй байдлын тухай хуулийн төсөлд; Зөвшөөрлийн хуулийн төсөлд санал, нэмэлт тайлбар, танилцуулга бэлтгэн Байнгын хорооны хуралд оролцож, саналаа тусгуулсан; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарах Харилцаа холбооны тухай хуулийн төсөлд санал өгч, ЦХХХЯ-ны саналд тусгуулсан; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Өргөн нэвтрүүлгийн хуульд хамаарах өөрчлөлтийг тусгуулсан; Цахим орчинд хүний эрхийг хамгаалах хуулийн төсөлд санал бэлтгэж ХЗДХЯ-д саналаа албан ёсоор хургуулж хамтран ажилласан болно.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран гамшгийн үед мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй бэлэн байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн харилцан хамтын ажиллагаа, удирдлага зохицуулалтаар хангах зорилготой “Мэдээлэл, харилцаа холбооны гамшгаас хамгаалах улсын албаны төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нэр томьёоны <https://dictionary.crc.gov.mn> цахим хуудсыг хөгжүүлж, системийн сайжруулалтыг хийж, гүйцэтгэгч талаас хүлээн авч, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэхээр туршилтыг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн болно.

Тайлангийн хугацаанд буюу 2022 оны эцсийн байдлаар, ХХЗХ-ны 2022 оны ээлжит, ээлжит бус нийт 14 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийтдээ 110 гаруй асуудлыг хэлэлцэн хуралдаж, зохицуулах хорооны хуралдаанаас баталсан 71 тогтоол шийдвэр болон 13 удаагийн хуралдааны тэмдэглэлийн нэгдсэн жагсаалтыг тайлангийн хавсралтад нэгтгэн үзүүлэв. (2022 оны тогтоол, шийдвэрийн судалгааг нэгтгэн үзүүлбэл):

- Зохицуулах хорооны үйл ажиллагаандaa хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг 50 гаруй байгаа бөгөөд ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 5 баримт бичгийн нэмэлтийг хянуулан бүртгүүлсэн;
- Захиргааны ерөнхий хууль, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөөр хэрэгжиж эхэлсэн Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай, 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэх Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр тогтоож баталсан 6;
- Зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, харилцан холболт, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, зохицуулалтын үйлчилгээний хөлс, төлбөрийн хэмжээ, Тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэлт, ашиглалт, хадгалалт, техникийн нөхцөл шаардлага, дугаарлалт, дүрэм журмыг ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 5 баримт бичгийг зохих хууль тогтоомжийн дагуу хүргүүлэн хянуулж бүртгүүлсэн болно.
- Шинээр болон шинэчлэн, нэгтгэн боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, өргөн нэвтрүүлэг, давтамжийн хуваарилалт, баталгаажуулалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-7;
- Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-9;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Өргөн нэвтрүүлгийн тухай, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай, Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу шинээр баталсан, шинэчилсэн, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хүчингүй болгосон-13 тогтоол, хавсралт баримт бичиг зэрэг болно.

ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлсэн хорооны тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулан ажилласан.

Харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн болон лавлах 30 гаруй үйлчилгээг E-mongolia.mn цахим системд холбосон ба хэрэглэгч E-mongolia болон www.license.crc.gov.mn цахим хуудсанд хандан харилцаа холбооны тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, эрхийн бичигтэй холбоотой үйлчилгээг цахим хэлбэрээр авах, хүсэлт илгээх боломжийг бүрдүүлэв.

Хорооны дарга, Дэд даргаас өгсөн үүрэг, чиглэл болон 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн, ДЗХ-ны үүрэг даалгаврыг тухай бүр биелэлтийг гаргаж, тайлагнан ажилласан болно. ХХЗХ-ны үйл ажиллагааны болон хорооны хуралдааны 2022 оны 1-4 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг холбогдох бүтцийн нэгтгэж, төлөвлөгөөг Хорооны даргаар 2022 оны тухай бүр тус тус батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр дүгнэн тайлагнав.

“Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”, “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн дагуу жил бүрийн эхний улиралд багтаан Хорооны хуралдаанд хорооны хуралдааны жилийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон баталсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт, цаашдын удирдамж, чиглэлийг авч ажилладаг болно. ХХЗХ-ны 2022 оны ээлжит 01 дүгээр хуралдаан /2022-01-31/-д “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2022 оны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт”-ийг боловсруулан хэлэлцүүлж, 2022 оны 01 дүгээр Хуралдааны тэмдэглэлээр холбогдох үнэлгээ, удирдамж чиглэл хугацаатай үүрэг даалгавар өгсөн бөгөөд энэхүү тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хорооны 2022 оны ээлжит 02 дугаар хуралдаанд 2021 оны 22 дугаар “Домэйн нэрийн нөөцийн жагсаалтыг батлах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт, 2022 оны ээлжит 6 дугаар хуралдаан, 2022 оны 07 дугаар, 2022 оны 12 дугаар хуралдаанд “Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт”-ын баримт бичгийн төслийн тухай; 2022 оны ээлжит 7 дугаар хуралдаанд ХХЗХ-нд 2022 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар танилцуулга; 2022 оны ээлжит 8 дугаар хуралдаанд “Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн зохицуулалтын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааны тайлан”-гийн танилцуулгыг тус тус хэлэлцүүлэн удирдамж чиглэл авч хэрэгжилтийг хангулан ажилласан.

Хорооны 2022 оны ээлжит 03 дугаар хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалт болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд ЗУХАГ болон ДХАА-наас нэгтгэн боловсруулсан “ХХЗХ-ны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайландаа хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай” танилцуулга, төлөвлөгөөний гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийн төслийн авч хэлэлцээд, Хорооны хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр “Хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай” хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэсэн. Уг тэмдэглэлд, Зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн

гүйцэтгэлийн тайлан материаллаг алдаагүй, НББ-ийн тухай хууль, СТОУС-д нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан Аудитын гэрчилгээнд илэрхийлсэн байдал, аудиторын зүгээс өгсөн санал, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Хорооны дарга, Санхүүгийн албанад тус тус үүрэг болгож, зөвлөмжийг хэрэгжүүлэн тайлагнан ажилласан болно.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.9 (45.9 дэх хэсгийн 45.9.1, 45.9.2 болон 45.9.3 заалтууд), 45.11 дэх хэсгүүд, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 287 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын 2.11 дэх хэсэгт тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хууль болон журмын дагуу хянан үзсэний дагуу шаардлага хангасан радио, телевизийн бүртгэлийн жагсаалтын төслийг авч хэлэлцэв. Тус хуралдааны тэмдэглэлээр, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэж, бүртгэгдсэн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйл, 38 болон 47 дугаар зүйлийн холбогдох хэсгүүдэд заасан үзүүлэлтүүдээр мониторинг хийх, мөн хуулийн 45.10 дах хэсэгт заасан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж байгаа эсэх талаар хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газарт үүрэг болгов. Тэмдэглэлээр баталсан нэр бүхий жагсаалтыг ХХЗХ, Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудаст байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж хамтран ажилласан.

ХДЗХЯ-наас ирүүлсэн ХХЗХ-ны баталсан захиргааны хэм хэмжээний актад хянуулан бүртгүүлсэн, бусад баталсан тогтоол шийдвэрийн талаар судалгааг ирүүлсэн загварын дагуу нэгтгэн боловсруулж, Даргын 2022-04-18 өдрийн 01/684 албан тоотоор хүргүүлэв.

ХХЗХ-ны ажлын албанаас 2022 оны эцсийн байдлаар, мэдээлэл харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зохицуулалтын баримт бичиг болох дүрэм журам, нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, төлбөрийн хэмжээ, зохицуулалтын үйлчилгээний хэмжээ тогтоох, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн эрх зүйн актад дүн шинжилгээ, мониторинг хийснээр Захиргааны ерөнхий хууль, хууль тогтоомжид нийцүүлэн дараах зохицуулалтын баримт бичгүүдийг ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэв. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит, ээлжит бус хуралдаанаар баталсан дараах тогтоолыг хавсралт баримт бичгийн хамт ЗУХАГ, Хуулийн хэлтэс, холбогдох газруудтай хамтран ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлж шийдвэрлэв. Үүнд:

- “Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжид ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д (Хорооны 2020 оны 37 тоот тогтоол) нэмэлт оруулах тухай: (2022 оны 01 тоот тогтоол: ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №4827);
- “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д (Хорооны 2020 оны 35 тоот тогтоол) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: (2022 оны 17 тоот тогтоол: ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №4825);

- “Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоох аргачлал”-ыг батлах тухай (Хорооны 2022 оны 18 тоот тогтоол);
- “Сансрын холбооны системд ашиглах радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №5948);
- “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурvasын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” шинэчлэн батлах тухай (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №5949);
- “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”-д (Хорооны 2022 оны 62 тоот тогтоол) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: (ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4903 бүртгэлтэй 2020 оны 62 тоот тогтоолд оруулсан 2022 оны 43 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн)
- Журам, аргачлал батлах тухай /2022 оны 53 тоот тогтоолын хавсралт-1: “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”; Хавсралт-2: “Бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журам”; Хавсралт-3: “Гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлал”, (ХЗДХЯ, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн дугаар №6061);
- Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах (Хорооны 2020 оны 89 тоот тогтоол) тухай: “ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4971 бүртгэлтэй 2020 оны 89 тоот тогтоолд оруулсан 2022 оны 59 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн);
- “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д (Хорооны 2021 оны 01 тоот тогтоол) нэмэлт оруулах тухай: (Хорооны 2022 оны 58 тоот тогтоол);
- “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн батлах тухай: (Хорооны 2022 оны 62 тоот тогтоол);
- Тогтоол хүчингүй болсонд (Хорооны 2021 оны 34 тоот тогтоол) тооцох тухай: (Хорооны 2022 оны 63 тоот тогтоол);
- “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам” (Хорооны 2021 оны 57 тоот тогтоол): (Хорооны 2022 оны 65 тоот тогтоол);
- “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам” батлах тухай (Хорооны 2022 оны 66 тоот тогтоол);
- “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023-2025 оны үйл ажиллагааны стратеги” батлах тухай (2022 оны 42 тоот тогтоол);
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай (2022 оны 67 тоот тогтоол) зэрэг тогтоол шийдвэрийг батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшилийн мэдээллийг маягтын дагуу хүлээн авч эмхэтгэн хорооны вэб хуудсанд (<https://crc.gov.mn/k/4x/9B>) байршуулж, олон нийтэд нээлттэй ил тод болгов.

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн ажиллах дотоод журам, зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХЗХ-ны даргын 2022 оны А/86 тоот тушаалын хавсралтаар

баталж, зөвлөлийн хурлыг 2022 онд удаа дараа зохион байгуулж зөвлөмж гарган холбогдох талуудад хүргүүлэх, сурталчлан ажиллаж байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж, гарын авлага боловсруулж, үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэн байгууллагын цахим хуудаст байршуулав. <https://crc.gov.mn/k/3cX>, <https://crc.gov.mn/list/rغ-n-nevtr-leg/mn?show=115>.

Хэт богино долгионы ФМ радиогийн сүлжээ, үйлчилгээний хүртээмж (газар нутгаар), үйлчилгээний нөхцөл байдал, үйлчилгээний чанарын байдлын талаар судалгаа, мэдээлэл гаргах ажлын хүрээнд радиогийн үйлчилгээний хүртээмж, зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгааг гүйцэтгэж тус хорооны вэб хуудсанд (<https://crc.gov.mn/l/23/0/6B>) байршуулан олон нийтэд мэдээлэн ажиллав.

ХХЗХ-ны ажлын албаны үйл ажиллагаа, үйл ажиллагааны болон төсөв, санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын хэсэг томилон ажиллуулах, хүний нөөц, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, Даргын зөвлөл, гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2022 онд Хорооны Даргын А-тушаал 337, Б-тушаал 105 тус тус батлан шийдвэрлэж, тушаалын хэрэгжилтийг хангуулан тайлagnаж ажиллав.

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хүрээнд шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлын байрны үзлэг хийж аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм, журам, нөхцөл, шаардлагын талаар 107, утсаар, уулзалтаар, цахим шуудангаар нийтдээ 100 гаруй иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2022 оны эцсийн байдлаар, Хорооны 2022 оны хуралдааны тогтоолоор шинэчлэн баталсан, шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм, журам, техникийн болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, өрсөлдөөний журам, үнэ тариф төлбөрийн хэмжээ, радио давтамжийн зохицуулалт, хуваарилалт зэрэг зохицуулалтын баримт бичгийг ХЗДХЯ-нд хянуулан бүртгүүлж шийдвэрлэсэнтэй холбогдуулан тус хорооны нийт 15 тогтоолыг хүчингүй болгов.

Хорооны 2022 оны ээлжит болон ээлжит бус 14 удаагийн хуралдааны мэдээний төслийг боловсруулж, баталсан тогтоол шийдвэр, тэмдэглэлийг албажуулах, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлсэн 2022 оны 12 тогтоол (2022 он: Тогтоол-01, 17, 37, 38, 43, 53, 59, 60, 61, 63, 65, 66) хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас ([www.crc.gov.mn](https://crc.gov.mn))-д тус тус байршуулан олон нийт, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт ил тод, нээлттэй, цахимаар авах боломжийг бүрдүүлэв.

2022 оны жилийн эцсийн байдлаар, ХХЗХ-ны хуралдаанаар холбогдох газар, хэлтсийн үнэлгээ, дүгнэлт болон сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт, саналыг болон ЗУХАГ-ын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн асуудлаар хорооны нийт 52 тогтоолыг батлан шийдвэрлэсэн ба 2022 онд 121 хуулийн этгээдэд 176 тусгай зөвшөөрөл шинээр олгосон, 19 хуулийн этгээдийн 29 тусгай

зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, 28 хуулийн этгээдийн 34 тусгай зөвшөөрлийг сэргээсэн, 113 хуулийн этгээдийн 142 тусгай зөвшөөрөл сунгасан, 111 хуулийн этгээдийн 141 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, 6 хуулийн этгээдийн 11 тусгай зөвшөөрлийг нэр шилжүүлсэн, 30 хуулийн этгээдийн 38 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Тусгай зөвшөөрлийн тогтоолуудыг албажуулан нийтдээ 350 гаруй холбогдох иргэн, хуулийн этгээд нарт мэдэгдэж, ЗУХАГ-тай зөвшөөрлийн гэрээг байгуулах, өөрчлөлт оруулсан, сунгах, нэр шилжүүлсэн, сэргээсэн, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон талаар мэдээллийн санд өөрчлөлт оруулан ажилласан.

- XXЗХ-ноос 2022 онд, радио давтамжийн эрхийн бичиг авах хүсэлт санал, ирүүлснээс нийт 260 гаруй санал дүгнэлт гаргаж, үүнээс шинээр 167, сунгалтаар 157, өөрчлөлт оруулсан 37, цуцлах 2 эрхийн бичгийг тус тус хянан шийдвэрлэв.

Радио долгионы хяналтын үйл ажиллагаанд “MNS ISO/IEC 17020:2013 – тохирлын үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага” стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсэг тус хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвд 2021 оны 12 дугаар сард итгэмжлэлийн үнэлгээ хийлгэж, 2022 оны 1 дүгээр сард итгэмжлэлийн хугацааг дахин 3 жилээр сунгуулан үйл ажиллагааг явуулж байна. Тус хороонд баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ авахаар 2022 онд ирүүлсэн нийт 480 гаруй хүсэлтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж Даргын тушаалаар олгохоор (шинэ-253, сунгалт-219) шийдвэрлэсэн байна.

Радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт, томилолтоор 2022 онд орон нутагт 192 байршил, Улаанбаатар хотод 32 харилцан нөлөөллийн гомдлыг шалгаж шийдвэрлэсэн, түүнчлэн цахилгаан соронзон орны хүний биед нөлөөлөх нөлөөллийн хэмжилт дүгнэлтийг нийт 34 удаа гаргаж ирүүлсэн санал, хүсэлтийг барагдуулсан байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОУЦХБ (ITU), АНДЦХБ (APT), АНДШБ (APRU), Олон улсын харилцаа холбооны хүрээлэн (IIC) зэрэг олон улс бүс нутгийн олон улсын байгууллагын их хурал, уулзалт, семинар болон Сингапур, Малайз улсын зохицуулах байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, урт ба богино хугацааны сургалтад хамрагдах, туршлага судлан хамтарсан уулзалт, семинарт давхардсан тоогоор байгууллагын 18 тооны удирдлага, албан хаагч, ажилтан нарыг хамруулав. Үүнд: Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ОУЦХБ)-ын Бүрэн Эрхт Төлөөлөгчдийн 21 дүгээр Их Хурал (Plenipotentiary Conference); Ази, номхон далайн цахилгаан холбооны байгууллагын Удирдлагын хорооны ээлжит 46 дугаар хуралдаан; Ази, номхон далайн шуудангийн байгууллагын гүйцэтгэх зөвлөлийн хурал; Дэлхийн радио их хуралд бэлтгэх бүсийн семинар; Олон улсын харилцаа холбооны хүрээлэн (IIC)-ийн чуулга уулзалт, Сингапур, Малайз улсын зохицуулах байгууллагын семинар Г.М.

Байгууллагын цахим хуудаст 2022 онд шинээр баталсан 71 тогтоол шийдвэр, ХЗДХЯ-нд шинээр бүртгүүлсэн 12 тогтоол болон хорооны хуралдааны тогтоолоор хүчингүй болгосон, шинэчлэн баталсан, нэмэлт өөрчлөлтийн жагсаалт, мэдээллийг ЗУХАГ-тай хамтран шинэчлэх арга хэмжээг авлаа.

Тайлангийн хугацаанд буюу 2022 оны эцсийн байдлаар, XXЗХ-ны 2022 оны ээлжит 6 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийтдээ 110 гаруй асуудлыг хэлэлцэн

зохицуулах хорооны хуралдаанаас баталсан 71 тогтоол шийдвэр болон 13 удаагийн хуралдааны тэмдэглэл баталсан.

Хорооны хуралдаанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар баталсан тогтоол, шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн тайланг нэгтгэн үзүүлэв:

№	Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар	Огноо	Тогтоол, тэмдэглэлийн төвч агуулга	Тайлбар
---	---	-------	------------------------------------	---------

Нэг. Хорооны хуралдааны тогтоол

1	Тогтоол 01	2022.01.31	"Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжид ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-д нэмэлт оруулах тухай (Хорооны 2020 оны 37 тоот тогтоол)	X3ДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/214 албан тоотоор хүргүүлэв. Х3ДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4827 бүртгэлтэй 2020 оны 37 тоот тогтоолд оруулсан 2022 оны 01 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлттэй 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Х3ДХЯ бүртгэсэн болно.
2	Тогтоол 02	2022.01.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 14 хуулийн этгээдэд 14 тусгай зөвшөөрөл Тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон ААН, хуулийн этгээд нарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/225 албан тоот /2022-02-07/-оор хүргүүлсэн. ЗУХАГ, Хуулийн хэлтсээс мэдэгдэл, зөвшөөрлийн гэрээг хүргүүлэн байгуулж, мэдээллийн санд шинээр тусган өөрчлөлт оруулсан. Тогтоолыг хавсралтын хамт ХХЗХ-ны цахим хуудас (www.crc.gov.mn)-т байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд хуралдааны шийдвэрийг нээлттэй болгох арга хэмжээг авч ажиллав.
3	Тогтоол 03	2022.01.31	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай	Тусгай зөвшөөрөл шилжүүлсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл Тогтоолоор тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн хуулийн этгээд нарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/226 албан тоот /2022-02-07/-оор хүргүүлсэн.
4	Тогтоол 04	2022.01.31	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай	Т3-ийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн: 37 хуулийн этгээдэд 47 тусгай зөвшөөрөл Тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлсэн ААН, хуулийн этгээд нар болон татвар, мэргэжлийн хяналтын хэлтэс, газарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/227 албан тоот /2022-02-07/-оор хүргүүлсэн.
5	Тогтоол 05	2022.01.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Т3 хүчингүй болгосон: 5 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрөл Тогтоолоор хүчингүй болгосон шийдвэрийг ААН, хуулийн этгээдэд ЗУХАГ, ХХНБД, Хуулийн хэлтсээс албажуулан /албан тоот: 07/228; 2022-02-07/ мэдэгдэл хүргүүлж, зөвшөөрлийн гэрээг цуцалж, мэдээллийн санд тусган өөрчлөлт оруулсан. Тогтоолыг

				хавсралтын хамт ХХЗХ-ны цахим хуудас (www.crc.gov.mn)-т байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд хуралдааны шийдвэрийг нээлттэй болгох арга хэмжээг авч ажилласан болно.
6	Тогтоол 06	2022.02.25	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 15 хуулийн этгээдэд 15 тусгай зөвшөөрөл Тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон ААН, хуулийн этгээд наарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/295 албан тоот /2022-03-01/-оор хүргүүлсэн. ЗУХАГ, Хуулийн хэлтсээс мэдэгдэл, зөвшөөрлийн гэрээг хүргүүлэн байгуулж, мэдээллийн санд шинээр тусган өөрчлөлт оруулсан.
7	Тогтоол 07	2022.02.25	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Т3 хүчингүй болгосон: 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл Тогтоолоор хүчингүй болгосон шийдвэрийг ААН, хуулийн этгээдэд ЗУХАГ, ХХНБД, Хуулийн хэлтсээс албажуулан /албан тоот: 07/296; 2022-03-01/ мэдэгдэл хүргүүлж, зөвшөөрлийн гэрээг цуцалж, мэдээллийн санд тусган өөрчлөлт оруулсан.
8	Тогтоол 08	2022.03.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 27 хуулийн этгээдэд 27 тусгай зөвшөөрөл Тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон 27 ААН, хуулийн этгээд наарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/470 албан тоот /2022-04-04/-оор хүргүүлсэн. ЗУХАГ, Хуулийн хэлтсээс мэдэгдэл, зөвшөөрлийн гэрээг хүргүүлэн байгуулж, мэдээллийн санд шинээр тусган өөрчлөлт оруулсан.
9	Тогтоол 09	2022.03.30	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	Т3 хүчингүй сэргээсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл Тогтоолоор сэргээсэн 1 тусгай зөвшөөрөл хуулийн этгээдэд ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/469 албан тоот /2022-04-04/-оор хүргүүлсэн. ЗУХАГ, Хуулийн хэлтсээс мэдэгдэл, зөвшөөрлийн гэрээг хүргүүлэн байгуулж, мэдээллийн санд сэргээсэн талаар шинээр тусган өөрчлөлт оруулсан.
10	Тогтоол 10	2022.03.30	Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай	Т3 нэмэлт өөрчлөлт оруулсан: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-04-04, 07/468)
11	Тогтоол 11	2022.03.30	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасаж, актлах саналын тухай	Хорооны 2022 оны 11 тоот тогтоолыг хавсралтын хамт ТӨБЗГ-т хүргүүлав. Энэхүү албан тоотын хариуг ТӨБЗГ-аас 2022 оны 7 дугаар ирүүлж, уг тогтоолын хавсралтад заасан хөрөнгийг актالж, данснаас хасахыг зөвшөөрсэн болно.
12	Тогтоол 12	2022.04.28	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 18 хуулийн этгээдэд 18 тусгай зөвшөөрөл (2022-05-02, 07/770)
13	Тогтоол 13	2022.04.28	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	Т3 хүчингүй сэргээсэн: 15 хуулийн этгээдийн 15 тусгай зөвшөөрөл (2022-05-02, 07/769)
14	Тогтоол 14	2022.04.28	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай	Тусгай зөвшөөрөл шилжүүлсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-05-02, 07/768)
15	Тогтоол 15	2022.04.28	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Т3 хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл (2022-05-02, 07/767)

16	Тогтоол 16	2022.04.28	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай (Хорооны 2021 оны 53 тоот тогтоол)	(2022-05-03, 07/766) 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл
17	Тогтоол 17	2022.05.26	"Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 35 тоот тогтоол)	ХЭДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/921 албан тоотоор хүргүүлэв. ХЭДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4825 бүртгэлтэй 2020 оны 35 тоот тогтоолд оруулсан 2022 оны 17 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ХЭДХЯ-наас бүртгэсэн болно.
18	Тогтоол 18	2022.05.26	"Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоо аргачлал"-ыг батлах тухай	ХЭДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/925 албан тоотоор хүргүүлэв. Дотоод үйл ажиллагаанд мөрдөхөөр тогтв.
20	Тогтоол 20	2022.05.26	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай (2021 оны 33 тогтоолын 8.2 заалтыг мөрдөх)	Тогтоолыг ШӨХТГ, МЦХ ХК, Лавлах үйлчилгээний төвүүдийн нэгдсэн холбоо зэрэг хуулийн этгээд, ТББ-д албан тоотоор хүргүүлэв. (2022-05-31, 07/923) Хорооны 2014 оны 38 тоот тогтоолыг хүчингүй болгов.
21	Тогтоол 21	2022.05.26	Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрөл (2022-05-31, 07/925)
22	Тогтоол 22	2022.05.26	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 16 хуулийн этгээдэд 16 тусгай зөвшөөрөл (2022-05-31, 07/924)
23	Тогтоол 23	2022.05.26	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай	Тусгай зөвшөөрөл шилжүүлсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-06-03, 07/929)
24	Тогтоол 24	2022.05.26	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Т3 нэмэлт, өөрчлөлт оруулсан: 5 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрөл (2022-05-31, 07/928)
25	Тогтоол 25	2022.05.26	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай	Т3-ийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн: 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрөл Тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлсэн ААН, хуулийн этгээд нар болон татвар, мэргэжлийн хяналтын хэлтэс, газарт ХХНБД-аас тогтоолыг албажуулан 07/927 албан тоот /2022-05-31/-оор хүргүүлсэн.
26	Тогтоол 26	2022.05.26	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Т3 хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл (2022-05-02, 07/926)
27	Тогтоол 27	2022.06.20	Тусгай зөвшөөрөл олгох тухай	Т3 шинээр олгосон: 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрөл (2022-06-24, 07/1048)
28	Тогтоол 28	2022.06.20	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	Т3 хүчингүй сэргээсэн: 8 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрөл (2022-06-24, 07/1047)
29	Тогтоол 29	2022.06.20	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай	Тусгай зөвшөөрөл шилжүүлсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-06-24, 07/1049)

30	Тогтоол 30	2022.06.20	Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	ТЗ нэмэлт өөрчлөлт оруулсан: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-06-24, 07/1050)
31	Тогтоол 31	2022.06.20	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	ТЗ хүчингүй болгосон: 7 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрөл (2022-06-24, 07/1046)
32	Тогтоол 32	2022.07.06	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 9 хуулийн этгээдэд 10 тусгай зөвшөөрөл (2022-07-07, 07/1126)
33	Тогтоол 33	2022.07.06	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай	ТЗ хүчингүй сэргээсэн: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-07-07, 07/1125)
34	Тогтоол 34	2022.07.06	Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	ТЗ нэмэлт өөрчлөлт оруулсан: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл. (2022-07-07, 07/1124)
35	Тогтоол 35	2022.07.06	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	ТЗ хүчингүй болгосон: 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөл (2022-07-07, 07/1123)
36	Тогтоол 36	2022.07.06	Тогтоолын холбогдох хэсгийг цуцлах тухай	ТЗ цуцалсан /ӨНЗГ/: 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөл (2022-07-07, 07/1120)
